



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Аудитор: О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19
6. Хавсралт: Төлбөрийн акт, албан шаардлага	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА
Л.БАЯРМАНДАЛ ТАНАА

2022.02.25 № 07/443
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>33,311,247,168.13</u>	<u>34,479,838,563.63</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>320,028,104.83</u>	<u>1,837,541,436.69</u>
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө	320,028,104.83	1,837,541,436.69
33	АВЛАГА	<u>9,248,680,688.43</u>	<u>8,911,836,864.43</u>
3305	Бусад авлага	<u>9,248,680,688.43</u>	<u>8,911,836,864.43</u>
330501	Байгууллагаас авах авлага	9,248,680,688.43	8,911,836,864.43
34	УРЬДЧИЛГАА	<u>21,180,292.09</u>	<u>16,857,811.37</u>
3406	Урьдчилж гарсан зардал	9,858,076.25	9,858,076.25
3407	Урьдчилгаа тооцоо	11,322,215.84	6,999,735.12
340701	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	10,254,115.84	6,999,735.12
340704	Томилолтын урьдчилгаа	1,068,100.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>545,967,729.50</u>	<u>538,212,097.86</u>
3503	Бэлэн бүтээгдэхүүн	30,925,195.00	50,911,710.00
3504	Хангамжийн материал	515,042,534.50	487,300,387.86
350401	Бичиг хэргийн материал	7,227,725.09	7,046,279.58
350402	Аж ахуйн материал	478,541,504.14	459,648,840.26
350403	Сэлбэг хэрэгсэл	23,747,304.91	18,316,149.91
350404	Түлш, шатах тослох материал	5,526,000.36	2,289,118.11
36	НӨӨЦИЙН БАРАА	<u>23,175,390,353.28</u>	<u>23,175,390,353.28</u>
3604	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,623,648,475.95</u>	<u>5,282,120,764.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>5,623,648,475.95</u>	<u>5,282,120,764.41</u>
3902	Биет хөрөнгө	4,973,471,396.69	4,842,821,250.77
390201	Барилга, байгууламж, орон сууц	3,042,801,473.59	3,042,801,473.59
39020101	Хуримтлагдсан элэгдэл	(178,251,813.84)	(267,377,720.76)
390202	Авто-тээврийн хэрэгсэл	2,738,917,149.94	2,684,462,355.11
39020201	Хуримтлагдсан элэгдэл	(2,247,690,265.36)	(1,968,958,299.68)
390203	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,695,499,145.94	6,222,445,420.04
39020301	Хуримтлагдсан элэгдэл	(5,659,280,147.44)	(5,396,141,144.63)
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,058,846,421.68	999,142,628.42
39020401	Хуримтлагдсан элэгдэл	(922,998,297.54)	(909,009,780.80)
390208	Бусад үндсэн хөрөнгө	940,674,575.47	940,674,575.47
390208	Хуримтлагдсан элэгдэл	(495,046,845.75)	(505,218,255.99)
3903	Биет бус хөрөнгө	650,177,079.26	439,299,513.64
390301	Програм хангамж	1,590,656,021.05	1,590,656,021.05
39030101	Хуримтлагдсан элэгдэл	(1,148,648,556.79)	(1,359,526,122.41)
390302	Бусад биет бус хөрөнгө	208,169,615.00	208,169,615.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,934,895,644.08</u>	<u>39,761,959,328.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР III=I+II	<u>914,312,074.00</u>	<u>1,919,185,153.00</u>
4101	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>914,312,074.00</u>	<u>1,919,185,153.00</u>
4103	Өглөг	914,312,074.00	1,919,185,153.00
410306	Бусад өглөг	914,312,074.00	1,919,185,153.00
41030601	Байгууллагад төлөх өглөг	914,312,074.00	1,919,185,153.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>38,020,583,570.08</u>	<u>37,842,774,175.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>38,020,583,570.08</u>	<u>37,842,774,175.04</u>
5101	Засгийн газрын оруулсан капитал	10,187,812,519.22	10,187,812,519.22
5102	Хуримтлагдсан үр дүн	25,387,327,667.08	25,209,518,272.04
510201	Өмнөх үеийн үр дүн	65,951,010,090.69	25,387,327,667.08
510202	Тайлант үеийн үр дүн	(40,563,682,423.61)	(177,809,395.04)
5103	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,445,443,383.78	2,445,443,383.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>38,934,895,644.08</u>	<u>39,761,959,328.04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	157,938,366,957.58	275,679,081,648.83
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,517,875,327.78	37,515,142,834.34
118	Бусад татвар, төлбөр, хураамж	40,517,875,327.78	37,515,142,834.34
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,517,875,327.78	37,515,142,834.34
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	32,796,080,664.67	33,106,146,607.42
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн олговор	7,721,794,663.11	4,408,996,226.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,395,452,789.49	234,778,641,214.49
120	Нийтлэг татварын бус орлого	113,395,452,789.49	234,778,641,214.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,635,232,197.58	36,631,865,330.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,229,572,753.47	33,382,832,647.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,067,562,642.04	3,247,945,564.73
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	338,096,802.07	1,087,118.00
120006	Газрын тосны орлого	102,757,324,312.16	198,145,306,083.00
120009	Бусад орлого	2,896,279.75	1,469,801.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,025,038,840.31	3,385,297,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,025,038,840.31	3,385,297,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,025,038,840.31	3,385,297,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	158,455,714,333.57	275,854,036,043.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,401,683,720.24	2,756,539,962.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,859,438,626.00	4,892,308,782.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,019,919,437.30	2,435,431,256.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	381,764,282.94	321,108,705.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,979,152.38	130,902,984.52
2104	Хангамж, бараа материалын зардал	176,262,159.20	185,994,885.95
2105	Нормативт зардал	396,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,915,992.91	76,515,689.77
2107	Томилолт, зочны зардал	52,488,868.52	59,923,584.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	753,979,656.90	763,891,297.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,220,733,075.85	918,540,378.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,596,275,707.57	270,961,727,260.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,003,255,692.29	1,841,864,188.87
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,499,678,395.39	268,772,033,396.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,826,371.87	75,496,705.95
213301	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	150,413,852,023.52	268,696,536,690.09
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	93,341,619.89	347,829,676.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,341,619.89	347,829,676.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 3=1-2	(517,347,375.99)	(174,954,394.91)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,046,335,047.62	2,855,000.13
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	40,014,079,834.89	2,855,000.13
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	32,255,212.73	
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН 5=3+4	(40,563,682,423.61)	(177,809,395.04)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,761,517,169.64	65,634,936,304.83	78,584,265,993.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(316,073,785.86)	316,073,785.86	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	65,951,010,090.69	78,584,265,993.69
Тайлант үеийн үр дүн			(40,563,682,423.61)	(40,563,682,423.61)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,387,327,667.08	38,020,583,570.08
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,387,327,667.08	38,020,583,570.08
Тайлант үеийн үр дүн			(177,809,395.04)	(177,809,395.04)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,209,518,272.04	37,842,774,175.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	157,993,790,682.03	277,026,681,675.83
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,517,875,327.78	37,515,142,834.34
118	Бусад татвар, төлбөр, хураамж	40,517,875,327.78	37,515,142,834.34
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,517,875,327.78	37,515,142,834.34
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	32,796,080,664.67	33,106,146,607.42
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	7,721,794,663.11	4,408,996,226.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,328,868,053.67	235,797,042,175.49
120	Нийтлэг татварын бус орлого	113,328,868,053.67	235,797,042,175.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,537,622,461.51	37,641,651,291.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,470,059,819.47	34,393,705,726.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,067,562,642.04	3,247,945,564.73
120006	Газрын тосны орлого	102,757,324,312.16	198,145,306,083.00
120009	Бусад орлого	33,921,280.00	10,084,801.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,147,047,300.58	3,714,496,666.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,113,750,840.31	3,714,496,666.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,025,038,840.31	3,385,297,600.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	88,712,000.00	329,199,066.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,296,460.27	0.00

131102	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,296,460.27	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,645,405,577.12	274,937,348,077.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,144,325,999.38	2,756,539,962.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,402,307,189.38	3,966,620,816.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,791,388,597.58	2,435,431,256.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	352,937,401.80	321,108,705.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,979,152.38	130,902,984.52
2104	Хангамж, бараа материалын зардал	150,232,369.41	135,530,146.76
2105	Нормативт зардал	1,706,000.00	865,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	95,906,282.52	85,421,423.77
2107	Томилолт, зочны зардал	51,698,568.52	58,855,484.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	783,458,817.17	798,505,814.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,243,098,387.74	270,970,727,260.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,293,879,306.46	1,841,864,188.87
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,828,877,461.39	268,772,033,396.04
213301	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,826,371.87	75,496,705.95
213302	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	329,199,066.00	
213303	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	150,413,852,023.52	268,696,536,690.09
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	120,341,619.89	356,829,676.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,341,619.89	356,829,676.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	348,385,104.91	2,089,333,598.53
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	28,357,000.00	571,820,266.67
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,357,000.00	571,820,266.67
2200	Дотоод эх үүсвэрээр	28,357,000.00	571,820,266.67
222001	Тоног төхөөрөмж	20,877,000.00	2,488,900.00
223001	Бусад хөрөнгө	7,480,000.00	569,331,366.67
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(28,357,000.00)	(571,820,266.67)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	320,028,104.91	1,517,513,331.86
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	320,028,104.83
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	320,028,104.91	1,837,541,436.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,090,259,900.00	5,015,038,028.55	75,221,871.45	98.5
УРСГАЛ ЗАРДАЛ	5,090,259,900.00	5,015,038,028.55	75,221,871.45	98.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,350,483,200.00	3,275,261,328.55	75,221,871.45	97.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,265,283,600.00	2,227,696,919.66	37,586,680.34	98.3
Үндсэн цалин	1,490,793,700.00	1,411,847,924.29	78,945,775.71	94.7
Нэмэгдэл	435,304,900.00	425,969,476.45	9,335,423.55	97.9
Унаа хоолны хөнгөлөлт	248,076,800.00	227,672,000.00	20,404,800.00	91.8
Урамшуулал	91,108,200.00	162,207,518.92	(71,099,318.92)	178
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	305,813,300.00	294,432,929.45	11,380,370.55	96.3
Тэтгэврийн даатгал	215,201,900.00	203,821,529.45	11,380,370.55	94.7
Тэтгэмжийн даатгал	22,652,800.00	22,652,800.00	0	100
ҮОМШӨ-ний даатгал	18,122,300.00	18,122,300.00	0	100
Ажилгүйдлийн даатгал	4,530,600.00	4,530,600.00	0	100
Эрүүл мэндийн даатгал	45,305,700.00	45,305,700.00	0	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,857,700.00	82,090,931.15	14,766,768.85	84.8
Гэрэл, цахилгаан	11,425,000.00	18,674,019.12	(7,249,019.12)	163.4
Түлш, халаалт	40,912,500.00	38,103,818.03	2,808,681.97	93.1
Цэвэр, бохир ус	22,292,700.00	3,085,594.00	19,207,106.00	13.8
Байрны түрээс	22,227,500.00	22,227,500.00	0	100
Хангамж, бараа материалын зардал	97,547,300.00	95,485,159.40	2,062,140.60	97.9
Бичиг хэрэг	22,371,900.00	21,914,370.00	457,530.00	98
Тээвэр, шатахуун	41,580,700.00	41,580,700.00	0	100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,393,900.00	14,943,586.40	(1,549,686.40)	111.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	523,300.00	526,520.00	(3,220.00)	100.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,677,500.00	16,519,983.00	3,157,517.00	84
Нормативт зардал	964,800.00	865,000.00	99,800.00	89.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	964,800.00	865,000.00	99,800.00	89.7
Эд хогшил, урсгал засварын зардал	27,423,500.00	25,764,156.98	1,659,343.02	93.9
Багаж, техник, хэрэгсэл	17,108,000.00	16,151,250.00	956,750.00	94.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,794,400.00	6,121,000.00	673,400.00	90.1
Урсгал засвар	3,521,100.00	3,491,906.98	29,193.02	99.2
Томилолт, зочны зардал	19,754,500.00	18,821,094.88	933,405.12	95.3
Дотоод албан томилолт	19,754,500.00	18,821,094.88	933,405.12	95.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	536,838,500.00	530,105,137.03	6,733,362.97	98.7

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	434,875,100.00	433,992,743.26	882,356.74	99.8
Даатгалын үйлчилгээ	29,711,900.00	28,520,600.00	1,191,300.00	96
Тээврийн хэрэгслийн татвар	5,214,800.00	5,214,800.00	0	100
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,290,000.00	1,252,819.00	37,181.00	97.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,920,400.00	55,526,573.77	4,393,826.23	92.7
Газрын төлбөр	2,800,000.00	2,572,101.00	227,899.00	91.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,026,300.00	3,025,500.00	800	100
Харуул хамгаалалтын зардал	44,436,000.00	44,242,000.00	194,000.00	99.6
Байр ашиглалтын үйлчилгээ	371,565,600.00	371,565,450.00	150	100
Зөвлөл хороо комиссын гишүүдийн ажлын хөлс	7,963,600.00	7,911,853.26	51,746.74	99.4
Лабораторийн итгэмжлэл	2,214,000.00	2,120,000.00	94,000.00	95.8
Мэдээлэл сурталчилгааны зардал	8,695,900.00	8,153,440.00	542,460.00	93.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,739,776,700.00	1,739,776,700.00	0	100.0
Бусад урсгал шилжүүлэг	1,739,776,700.00	1,739,776,700.00	0	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,704,962,300.00	1,704,962,300.00	0	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,063,000.00	32,063,000.00	0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,751,400.00	2,751,400.00	0	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,090,259,900.00	5,015,038,028.55	75,221,871.45	98.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,704,962,300.00	1,705,237,134.50	274,834.50	100.0
Улсын төсвөөс санхүүжих	3,385,297,600.00	3,309,800,894.05	75,496,705.95	97.8
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих /сургалт өөрийн орлогоос/	1,704,962,300.00	1,705,237,134.50	274,834.50	100.0
Байгууллагын тоо	1	1	0	100.0
Төсвийн байгууллага	1	1	0	100.0
АЖИЛЛАГСАД БҮГД	172	172	0	100.0
Удирдах ажилтан	13	13	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	105	105	0	100.0
Үйлчлэх ажилтан	32	32	0	100.0
Гэрээт ажилтан	22	22	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	1,365,267,243.37
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	0	1,365,267,243.37
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	0	691,359,487.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	456,949,374.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	0	207,734,337.26
210101	Үндсэн цалин	0	350,037.73
210105	Гэрээт ажлын хөлс	0	207,384,299.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	26,675,776.05
210201	Тэтгэврийн даатгал	0	26,675,776.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	48,812,053.37
210301	Гэрэл, цахилгаан	0	824,178.87
210302	Түлш, халаалт	0	3,465,714.50
210303	Цэвэр, бохир ус	0	205,260.00
210304	Байрны түрээс	0	44,316,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	40,044,987.36
210401	Бичиг хэрэг	0	1,530,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	9,918,947.36
210406	БҮТЭЗүйлс	0	28,596,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	59,657,266.79
210604	Урсгал засвар	0	59,657,266.79
2107	Томилолт, зочны зардал	0	40,034,390.00
210702	Дотоод албан томилолт	0	40,034,390.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	268,400,677.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	268,400,677.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	102,087,488.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	102,087,488.87
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	102,087,488.87
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	0	571,820,266.67
2200	Дотоод эх үүсвэрээр	0	571,820,266.67
222001	Тоног төхөөрөмж	0	2,488,900.00
223001	Бусад хөрөнгө	0	569,331,366.67
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	1,542,708,430.23
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	0	1,542,708,430.23
12000421	Төлөөлөгчийг дэмжих сангийн орлого	0	1,542,708,430.23
31	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0	320,028,104.83
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0	497,469,291.69

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад урьдчилж орсон орлогыг үнэ зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын аудитор М.Лхагвасүрэн, О.Баярмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитын менежер Д.Энхдалай, Захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/493 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ашигт малтмал, газрын тосны газар нь “Төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх” зорилго дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус газар нь геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт УИХ, ЗГ, УУХҮЯ-аас гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахаас гадна холбогдох хууль, журмын биелэлтийг хангах зорилтуудын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Геологи хайгуулын салбарын чиглэлээр: Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хатуу, шингэн, хийн төлөвт ашигт малтмалын геологи хайгуулын судалгааг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх зорилтын хүрээнд ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эрэл хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг хянан хүлээн авах, хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд хүлээн авч, бүртгэх;

2. Уул уурхайн салбарын чиглэлээр: тус салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд уулын ажлын төлөвлөгөө, тайланг хянан хүлээн авах, уулын болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хянах, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, салбарын аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэгтгэж, түүнд тулгуурласан судалгаа, санал, дүгнэлт боловсруулах;

3. Газрын тосны салбарын чиглэлээр: Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд тус салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд газрын тосны эрэл, хайгуулын ажлыг

эрчимжүүлж нөөцийг өсгөх, ордыг ашиглалтад шилжүүлэх, тосны олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг тогтвортой хангах, газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц бүрдүүлэх, үнийн судалгаа явуулах, дотоодын жижиглэнгийн үнийг тогтвортой байлгахад хяналт тавих;

4. Хүнд үйлдвэрийн чиглэлээр салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэн шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг хэрэгжүүлэх, энэ салбарын хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах, инновацын идэвхжилтийн судалгааг хийх чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс тайлант оны худалдан авах ажиллагаа Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн актад нийцэж байгаа эсэх, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлсэн байдалд дотоод аудит хийж дараах зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.2.10-т заасан гэрээг дүгнэж, бараа ажил үйлчилгээг хүлээн авсан баримт, материалыг бүрдүүлж архивладаг байх. Захиалагч үнэлгээний хороо байгуулах тушаалд тухайн гэрээний хэрэгжилтийг хариуцаж гэрээг дүгнэж бараа ажил үйлчилгээг хүлээн авах албан тушаалтныг тодорхой зааж өгөх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.2-т “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах;
- Үнэлгээний хороо байгуулах тушаал гаргахдаа, гишүүдийн А-3 гэрчилгээний хугацааг тендерийн хүчинтэй байх хугацаатай нийцэж буйд анхаарч тушаал төлөвлөж гаргах.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн орлого 157,938,366.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,579,383.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны үр дүнгийн тайлангийн орлого 257,679,081.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,576,790.8 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 827.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэлд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	320,028.1	1,837,541.4	1,517,513.3
Авлага	9,248,680.7	8,911,836.9	(336,843.8)
Урьдчилгаа	21,180.3	16,857.8	(4,322.5)
Бараа материал	545,967.7	538,212.1	(7,755.6)
Нөөцийн бараа	23,175,390.3	23,175,390.3	-
Үндсэн хөрөнгө	5,623,648.5	5,282,120.8	(341,527.7)
Нийт хөрөнгө	38,934,895.6	39,761,959.3	827,063.7
Өр төлбөр	914,312.1	1,919,185.1	1,004,873.0
Засгийн газрын оролцоо	10,187,812.5	10,187,812.5	-
Хуримтлагдсан үр дүн	25,387,327.6	25,209,518.3	(177,809.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,445,44.4	2,445,443.4	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	38,934,895.6	39,761,959.3	827,063.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,517,513.3 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцсон боловч шалгараагүй аж ахуй нэгжүүд төлбөрийн буцаалтаа аваагүй;
- Үндсэн хөрөнгө 341,527.7 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын тогтоолоор тээврийн хэрэгсэл худалдан авсан, Үндэсний геологийн албанд балансаас балансад хөрөнгө шилжүүлсэн, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж данснаас хассан;
- Өр төлбөрийн данс өмнөх оноос 1,004,873.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зөвшөөрөл авах хүсэлтийн төлбөр төлсөн боловч тухайн үйлчилгээг аваагүй байгууллагуудын өглөг, сонгон шалгаруулалтад шалгараагүй байгууллагуудын төлбөрийн буцаалтын өглөгүүд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,491,676.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,704,962.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,196,639.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 106,379.3 мянган төгрөгөөр бууруулж 5,090,259.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,090,259.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,385,297.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,704,962.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,385,297.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,705,237.1 мянган төгрөг, нийт 5,090,534.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,015,038.0 мянган төгрөгийг зарцуулж 75,496.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,015,038.0 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг 48,967.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 14,766.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,062.1 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 99.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,659.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 6,733.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	70905	Олборлолт, уул уурхай	5,090,259.9	5,015,038.0	75,221.9	98.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,915,608.1	2,841,268.6	74,339.5	97.5
1.2	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	8,695.9	8,153.4	542.5	93.8
1.3	80219	Харуул, хамгаалалтын зардал	44,436.0	44,242.0	194.0	99.6
1.4	80224	Зөвлөл, хороо комиссын гишүүд	7,963.6	7,911.8	51.8	99.3
1.5	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	371,565.6	371,565.5	0.1	100.0
1.6	80227	Лабораторийн итгэмжлэл	2,214.0	2,120.0	94.0	95.8
1.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	34,814.4	34,814.4	-	100
1.8	81820	Сургалтын төлбөр, буцалтгүй тусламж	1,704,962.3	1,704,962.3	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлогоос 1,542,708.4 мянган төгрөг төвлөрч, нийт 1,365,267.2 мянган төгрөг зарцуулан, жилийн эцэст 497,469.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.5 хувийн биелэлттэй, 1.5 хувь буюу 75,221.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдаж, усан сан бүхий газрын ойр ашигт малтмал хайх олборлохыг хориглосон.

Үүнтэй холбоотой ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хүчингүй болгосоноор 2012 оноос өмнө тусгай зөвшөөрөл олгосон 124 байгууллага нөхөн олговор авах хүсэлт гаргасаар байгаа нь зарим эрх бүхий албан тушаалтан эрсдэл тооцоололгүй тусгай зөвшөөрөл олгосонтой холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд нийт байршуулбал зохих 729,026,414.8 мянган төгрөгийн 2096 мэдээллээс 2063 мэдээллийг хугацаанд мэдээлсэн, тушаал шийдвэртэй холбоотой 536,073.6 мянган төгрөгийн 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,263,198.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, 1,239,752.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар өгсөн 4 албан шаардлагын биелэлт 21.6 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Хүснэгт 3

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	23,445.7	2	23,445.7	0	-	100.0
Албан шаардлага	4	1,239,752.7	3	267,858.6	1	971,894.1	21.6
Зөвлөмж	1	-	1	-	0	-	100.0
Нийт дүн	7	1,263,198.4	6	291,304.3	1	971,894.1	23.1

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусган, батлуулж байх албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны орлого, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн орлого бүрдүүлэлтийг мөнгөн сууриар бүртгэснээс хяналт суларч найдваргүй авлага их хэмжээгээр үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,426,354.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,611,969.0 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,558,880.1 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 555,505.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд "Доншен газрын тос монгол ХХК" нь газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлбөл зохих төлбөрөөс 864,830.30 ам.доллар буюу 2,463,728.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8.1-т "Гэрээлэгч хуанлийн улирал бүрд борлуулсан Гэрээт тосны үнийн хэмжээний 7.5 хувьтай тэнцэх хэмжээний роялти төлнө", 8.3-т "Бүтээгдэхүүн хуваах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийгдсэн ордод ашиглалт явуулахаар гэрээ байгуулсан нэр бүхий 11 байгууллагын 148,240.4 мянган төгрөгийн төлбөрийг дутуу төлүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх тухай гэрээ"-ний 2.2-т "Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурдсан хугацаанд төлөхөөр хуваарилсан төлбөрийг хавсралт 1-д заасан хугацаанд Төрийн сан банкны төгрөгийн 100900000722 тоот АМГТГ-ын Нөхөн төлбөрийн дансанд төлнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийг акт тогтоох.

4.2 Албан шаардлага

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх сургалтын урамшууллын болон төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн орлого 1,626.0 мянган ам.доллар буюу 4,632,148.8 мянган төгрөг, мөн 2014-2015 онуудад Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх нэр бүхий 9 байгууллагаас авах авлагын 8,334,166.9 мянган төгрөг, Томас эйр ХХК-д урьдчилан шилжүүлсэн нислэгийн зардлын 9,858.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлсэн боловч хэрэгжүүлсэн ажлын үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 6.2.2-т "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хэмжээгээр төлнө", 6.2.3-т "Сургалтын урамшууллыг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хэмжээгээр төлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх сургалтын урамшууллын болон төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн орлогыг авлага, өглөгөөр тайлагнаж шат дараалсан хяналтыг сайжруулах албан шаардлага өгөх.

2. Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулаагүй 1,365,267.2 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.6.2-т "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлж, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлага өгөх.

3. Өмнөх онд урьдчилан төлсөн хайгуулын 94,404.5 мянган төгрөг, ашиглалтын 99,208.4 мянган төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг урьдчилж орсон орлогоор бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан зааврын 2.8-д "Ажил үйлчилгээг нийлүүлээгүй байхад хүлээн авсан орлогыг урьдчилж орсон орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомж, сангийн сайдын тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урьдчилж орсон орлогын холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сонгон шалгаруулалтын орлого болох нэр бүхий 6 байгууллагын 9,681.8 мянган төгрөгийн "Урьдчилж орсон орлого"-ыг байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн, мөн эзэн холбогдогч нь тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан зааврын 2.8-д "Ажил үйлчилгээг нийлүүлээгүй байхад хүлээн авсан орлогыг урьдчилж орсон орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Урьдчилж орсон сонгон шалгаруулалтын орлогыг үнэн зөв тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2. Зарлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас "Газрын тосны тэргүүний ажилтан тэмдэг"-ийг хэвлүүлэхэд 9,750.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх ..." заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		ҮҮНЭЭС					
							Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар												
1	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Тайлант онд "Доншен газрын тос монгол ХХК" нь газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлбөл зохих төлбөрөөс 864,830.30 ам.доллар буюу 2,463,728.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлбөл зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх	1	2,463,728.6	1	2,463,728.6				
2	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийхэд гарсан зардлыг нөхөн төлөхөөр гэрээ байгуулсан нэр бүхий 11 аж ахуйн нэгж байгууллагын 148,240.4 мянган төгрөгийг дутуу төлүүлсэн.	Гэрээний дагуу төлбөл зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх	1	148,240.4	1	148,240.4				
3	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх сургалтын урамшууллын болон төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн орлого 1,626.0 мянган ам доллар, мөн 2014-2015 онуудад Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх нэр бүхий 9 байгууллагаас авах авлагын 8,334,166.9 мянган төгрөг, Томас эйр ХХК-д урьдчилан шилжүүлсэн нислэгийн зардлын 9,858.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлсэн боловч хэрэгжүүлсэн ажлын үр дүн хангалтгүй	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн орлогыг авлага, өглөгөөр тайлагнаж шат дараалсан хяналтыг сайжруулах	1				1			
4	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулаагүй 1,365,267.2 мянган төгрөгийг зарцуулсан.	Төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлэх	1	1,365,267.2			1	1,365,267.2		

Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Өмнөх онд урьдчилан төлсөн хайгуулын 94,404.5 мянган төгрөг, ашиглалтын 99,208.5 мянган төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг урьдчилж орсон орлогоор бүртгэлд тусгаж тайлагнаагүй,	Холбогдох хууль тогтоомж, сангийн сайдын тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах	1	193,612.9			1	193,612.9		
6	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас "Газрын тосны тэргүүний ажилтан тэмдэг"-ийг хэвлүүлэхэд 9,750.0 мянган төгрөгийг зарцуулсан.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	9,750.0					1	9,750.0
7	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Сонгон шалгаруулалтын орлого болох нэр бүхий 6 байгууллагын 9,681.8 мянган төгрөгийн "Урьдчилж орсон орлого"-ыг байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн, мөн эзэн холбогдогч нь тодорхойгүй байна.	Урьдчилж орсон орлогыг үнэн зөв тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	9,681.8					1	9,681.8
Дүн					7	4,190,280.9	2	2,611,969.0	3	1,558,880.1	2	19,431.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
8	АМГТГ	АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд нийт байршуулбал зохих 729,026,414.8 мянган төгрөгийн 2096 мэдээллээс 2063 мэдээллийг хугацаанд мэдээлсэн, тушаал шийдвэртэй холбоотой 536,073.6 мянган төгрөгийн 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах	1	536,073.6					1	536,073.6
Дүн					1	536,073.6	0	0			1	536,073.6
Нийт дүн					8	4,726,354.5	2	2,611,969.0	3	1,558,880.1	3	555,505.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 42/А040085

Улаанбаатар хот

АХГ-2022/218/НА-СТА-ТУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тайлант онд Доншен газрын тос монгол ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлбөл зохих төлбөрөөс 864,830.30 ам.доллар буюу 2,463,728,558.64 төгрөгийг дутуу төвлөрүүлсэн,
2. Улсын төсвөөс хайгуулын ажилд зарцуулсан зардлыг нөхөн төлөхөөр гэрээ байгуулсан нэр бүхий 11 аж ахуйн нэгж, байгууллагын 148,240,394.13 төгрөгийг дутуу төлүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "Хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8.1 "Гэрээлэгч хуанлийн улирал бүрд борлуулсан гэрээт тосны үнийн хэмжээний 7.5 хувьтай тэнцэх хэмжээний роялти төлнө" 8.3 "Бүтээгдэхүүн хуваах", Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх тухай гэрээний 2.2 "Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурдсан хугацаанд төлөхөөр хуваарилсан төлбөрийг хавсралт 1-д заасан хугацаанд Төрийн сан банкны төгрөгийн 100900000722 тоот АМГТГ-ын Нөхөн төлбөрийн дансанд төлнө" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх тухай гэрээний дагуу төлөх нийт 2,611,968,952.77 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, ерөнхий нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР


АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

М.ЛХАГВАСҮРЭН

О.БАЯРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05 № 234/А0140085
АХГ-2022/218/НА-СТА-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулаагүй 1,365,267,243.38 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.6.2 "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлогыг төсөвт тусгаж батлуулах Төсвийн тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, ерөнхий нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Д ЭНХДАЛАЙ
М ЛХАГВАСҮРЭН
О БАЯРМАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-246.Docx

0010860774



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 235/А0170085

Улаанбаатар хот

АХГ-2022/218/НБ-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд урьдчилан төлсөн хайгуулын тусгай зөвшөөрлийн 94,404,470.00 төгрөгийн, ашиглалтын тусгай зөвшөөрлийн 99,208,469.00 төгрөгийн, нийт 193,612,939.00 төгрөгийн төлбөрийг урьдчилж орсон орлогоор данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны зааврын 2.8 "Ажил үйлчилгээг нийлүүлээгүй байхад хүлээн авсан орлогыг урьдчилж орсон орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урьдчилан төлсөн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн данс бүртгэлд тусгаж, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, ерөнхий нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-245.Docx

0010800770



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 236/А0140085

Улаанбаатар хот

АХГ-2022/218/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант онд газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх сургалтын урамшууллын болон төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн орлого 1,626,000.0 ам доллар буюу 4,632,148,800.00 төгрөг төвлөрүүлээгүй,
2. Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 2014-2015 онд улсын төсөвт төвлөрүүлээгүй авлага үүсгэн бүртгэсэн нэр бүхий 9 байгууллагын 8,334,166,864.43 төгрөг, Томас эйр ХХК-д урьдчилан шилжүүлсэн нислэгийн зардлын 9,858,076.25 төгрөг, нийт 12,976,173,740.68 төгрөгийн авлагыг барагдуулаагүй асуудлыг тус тус шүүхэд шилжүүлсэн боловч хэрэгжүүлсэн ажлын үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 6.2.2 "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хэмжээгээр төлнө", 6.2.3 "Сургалтын урамшууллыг гэрээт жил эхэлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хэмжээгээр төлнө" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх сургалтын урамшууллын болон төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн орлогыг авлага, өглөгөөр тайлагнах, авлагыг барагдуулах, шат дараалсан хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, ерөнхий нягтлан бодогч Х.Чулуунцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
Д ЭНХДАЛАЙ
М ЛХАГВАСҮРЭН
О БАЯРМАА

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the conclusion.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the summary.